

Хэсэг 5

Төрийн эрх мэдэл шилжүүлэлт амьдрал дээр: Зуд, отор болон нүүдлийн мал аж ахуйн өмнө тулгарч буй эрсдлийн мөн чанар

Даниел Ж. Мёрфи

Редакторын тайлбар: Монголын малчид олон тооны малаа зарим жил тохиох хатуухан өвлөөр алдан ихээхэн хохирол амсдаг нь Монголын нийгэмд байнга тохиолдох, онцлох шинж нь болсоор ирсэн. Гэвч байгаль орчны болон амьжиргааны стресс (дарамт) нь өнөөгийн Монголыг өөрчилж байна гэсэн дүгнэлтийг доктор Даниэл Мёрфи чамгүй нухацтай хийсэн судалгааныхаа дүнд хийжээ. Хэдийгээр Монголын хүн амын нэлээд хэсэг нь хөдөөгийн өргөн уудам нутагт нүүдлийн мал аж ахуй эрхлэн амьдарч байгаа боловч хахир хатуу өвлийн нөхцөлд малын хорогдол багатай байх зорилгоор бэлчээр сэлгэн нүүдэллэх боломж, чадал тааруухан байна. Харьцангуй чинээлэг, том, эрх мэдэлтнүүдтэй харилцаа холбоо сайтай малчдын бүлэг нь хөрөнгө тааруухантай, багавтар малчдын бүлэгтэй харьцуулахад өвлийн хатуу ширүүн цагт мал сүргээ амжилттайгаар нутаг сэлгэн бэлчээрлүүлдэг байна. Энэ байдал нь социализмын дараах орон нутгийн засаг захиргааны нэгжсийн улс төрийн алдаатай холбоотой, өөрөөр хэлбэл, цаг уурын хүндрэлтэй байгаа нутгаас түр зуур бэрхшээл хүндрэл багатай нутаг руу бэлчээр сэлгэн нүүдэллэх зөвшөөрлийг хөрөнгө чинээ, бүл муутай малчид олж авахад амаргүй байдаг аж. Хүнд байдалд орсон малчид цаашид мал маллан амьдрахад хэцүү болж өөрсдийн малыг зарж борлуулан өөрсдөө нэг бол олон малтай малчдын малыг маллах хөлсний малчин болох, эсвэл нийслэл, хот суурин газар бараадан ажил амьдрал хайн амьдрах болсон нь энэ уудам нутагт ажилгүй, малгүй болсон малчдын тоог нэмэгдүүлэхэд хүргэж байна. Үүний үр дүнд хөдөөгийн ядуурал, амьдралын хэв маягийн өөрчлөлт, амьдрах орон зайн сэлгэлт болон хэт

хамаарал зэрэг нь хөдөөгийн засаг захиргаанд нүүрлээд байгаа асуудлуудын нэг болоод байгаа ч ихэнх тохиолдолд тэдгээрийг хайхрахгүй, асуудлыг зөвөөр дэвшүүлэхгүй орхигдуулдаг байна.

Удиртгал

1991 оноос хойш Монгол улсын орон нутгийн удирдлагад эрс өөрчлөлт бий болсон. Эдгээр өөрчлөлтийн ихэнх нь шилжилтийн эхэн үед улсын төсвийн орлого буурч, төсвийн хомсдол үүсч, төсөв санхүүгийн бодлого эрс шинэчлэгдэн, үндэсний эдийн засгийн хөгжлийн зорилтууд өөрчлөгдсөнтэй холбоотой юм (Фернандес-Гименез, Батбуян, 2004 он). Энэ үеэс хойш орон нутгийн засаг захиргааны талаар баримтлах бодлогод төвлөрлийг сааруулах, орон нутгийн чадавхийг бэхжүүлэх гэсэн хоёр чиглэл давамгайлах болсон. Хэрэгжилтийн түвшинд энэ хоёр зарчим нэгдүгээрт, орон нутгийн нөөц хөрөнгийг удирдах захиргааны үүрэг хариуцлага сум, багийн Засаг дарга нар, ИТХ-д шилжих, хоёрдугаарт, олон нийтэд түшиглэсэн хөрөнгө нөөцийн менежментийг хэрэгжүүлэх байгууллагууд нь нэгдэл задарснаар үүссэн хоосон орон зайг нөхөх, орон нутгийн засаг захиргааны институцийн оролцоог орлох арга хэрэгсэл хэмээн сурталчилан хөгжүүлэх арга хэлбэрээр биеллээ олж байна. Эдгээр стратеги нь бизнесийн салбарт хэрэглэдэг франчайзингийн загварыг төрийн эрх мэдлийг хүрээнд шилжүүлэн хэрэглэх буюу өөрөөр хэлбэл, төрийн эрх мэдлийг төрийн бус гүйцэтгэгчдэд шилжүүлэх, эсвэл шийдвэр гаргалтад хүчтэй нөлөөтэй төрийн бүтцүүдийн эрх мэдэл нэмэгдэж тэдний ‘үг’ буюу шийдвэр нь төрийн шийдвэрийн хэмжээний хүчтэй болох нөхцөл байдлыг үүсгэж байна.

Эдгээр бодлого нь ирээдүйн Монголын эдийн засагт нүүдлийн мал аж ахуйн ач холбогдол улам буурахаар төсөөлж буй бодлого боловсруулагчдын хандлагад суурилсан учраас

мөн чанар нь маш нео-либерал шинжтэй байгаа билээ. Хэдийгээр малчид Монголын хүн амын нэлээд хувийг эзэлдэг ч бодлогын үйл явц дахь тэдний оролцоо, мөн тэдний улс төрийн сонголт нь уул уурхай зэрэг эдийн засгийн үр өгөөж хамаагүй ихтэй салбарт хандуулах анхааралд дарагдан, чухалчлан анхаарагдахгүй байсаар байна. Энэ хандлага дээр улам бүр хотжин, “орчин үежиж” буй Монголын нийгэмд малчдын ахуйн соёл мөн л шахагдаж байгаа явдал нэрмээс болж байна. Цашилбал, төрийн франчазингийн загварыг “үр ашигтай” хэмээн магтан, төв засгийн газрын хэмжээг багасгах, зах зээлийн эдийн засгийн үндэс суурийг бэхжүүлэх арга хэрэгсэл мөн хэмээн сурталчилж байгаа билээ. Энэхүү товч өгүүлэлд судлаач миний бие бодлогын энэхүү өөрчлөлт нь хөдөө орон нутгийн хөрөнгө нөөцийн менежмент, малчдын шилжилт хөдөлгөөн, малчин өрхүүдийн дунд эрсдлийг хуваарилах зэрэгт хэрхэн нөлөөлж буйг харуулахыг зорьлоо. Мөн сүүлийн хэдэн жилд учирсан зудын ноцтой нөлөө нь байгалийн хүчин зүйл бус харин төр-нийгмийн харилцаанд гарсан нео-либерал өөрчлөлтүүдийн нөлөө хэмээн үзэж байгаагаа тайлбарлахыг хичээлээ.

Ерөнхий мэдээлэл: судалгааны талбар ба арга зүй

Энэхүү нийтлэлд ашигласан өгөгдөл, мэдээллийг 2007 оны 12 дугаар сараас 2008 оны 11 дүгээр сар хүртэлх хугацаанд Монголын зүүн хэсгийн Хэнтий¹ аймгийн Баянхутаг сумын Цантын Овоо хэмээх 3 дугаар багийн нутагт цуглуулав. Албан бүртгэлээр, Өгөөмөр баг нийт 166 өрхийн 609 иргэнтэй.

¹ Өгөөмөр баг хэмээх нэр томъёог ашиглаж байгаа нь маргаантай асуудал юм. Энэ нутаг дэвсгэрийг гуравдугаар баг хэмээн нутгийн хүмүүс нэрлэдэг бөгөөд албан ёсны бичиг баримтад Цантын Овоо гэж нэрлэдэг. Гэхдээ гуравдугаар баг гэсэн нэр нь хэр ерөнхий, харин Цантын Овоо гэдэг нэр нь төдийлөн танигдаагүй, хэрэглэж заншаагүй нэр юм. Энэ нутгийн ихэнх хэсгийн нутгийн төвд орших том уулын нэрээр Өгөөмөр баг гэж нэрлэсээр ирсэн түүхтэй. Багийн хэсэг болгон нь өөрийн газар зүйн нэртэй бөгөөд эдгээрийн зарим нь бусад сум, багийн нутаг дэвсгэр лүү хальж ордог. Иймээс Бурханы шашинтай найзынхаа дундыг баримтлах тухай үргэлж захидаг ёсоор би судалгааны нутаг дэвсгэрээ Өгөөмөр баг гэж нэрлэж байгаа болно.

Харин Өгөөмөр багт албан ёсны бүртгэлтэй иргэдийн дотор багийн нутаг дэвсгэр дээр амьдардаггүй, амьдардаг ч мал ахуй эрхэлдэггүй хүн нэлээд бий. Өнөөдөр 139 өрх л мал аж ахуй эрхэлж байгаа бөгөөд малчин өрхүүдийн ихэнх нь мал ахуйн бүтээгдэхүүнээр амьдардаг. Энэхүү судалгаанд эдгээр өрхийн 68 нь хамрагдсан бөгөөд судалгааны мэдээллийг ярилцлага, ажиглалтын аргаар бүрдүүллээ. Мөн судлаач миний бие 12 сарын туршид малчин өрхүүдтэй амьдарч, тэдний өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаанд аль болох идэвхтэй оролцож ирснийг тэмдэглэн хэлье.

Шилжилт хөдөлгөөн ба эрсдэл

Зуднаас үүдэлтэй малын хорогдол нь хөдөөгийн нийгмийн амьдралын өөрчлөлттэй холбоотой болохыг харуулах нотолгоог мал сүргийн болон учрах эрсдлийн менежментийг малчин өрхүүд хэрхэн хийж байгаагаас харж болно. Өгөөмөр сумын малчин өрхүүдэд чоно нохой, махчин шувуу, өвчин, хулгай зэрэг бага хэмжээний эрсдлийн зэрэгцээ үер, ган, хаврын салхи, өвлийн шуурга, зуд турхан зэрэг ноцтой эрсдэл тулгарна. Эдгээр хүчин зүйлийн ихэнх нь мал хорогдох эрсдэл дагуулах боловч зарим нь ийм эрсдэл дагуулахгүйн дээр ган зэрэг зарим байгалийн хүчин зүйлтэй холбоотой хүчин зүйл нь өргөн нутаг дэвсгэрийг хамрах бол махчин амьганд малаа бариулах зэрэг эрсдэл нь *орон нутгийн шинжтэй* буюу хор хөнөөл нь нэг өрхийн хүрээнээс халихгүй байх онцлогтой. Шороон шуурга зэрэг тохиолдлын шинжтэй эрсдэл нь улирлын чанартай ч давтамж нь өндөр байдаг бол үер хэдийгээр ховор, давтамж багатай үзэгдлүүд юм. Зуд бол хор хөнөөлийн хувьд гамшгийн хэмжээнд хүрч болох эрсдэл бол малын хулгайнаас учрах хохирол бага байх магадлалтай.

Малчид, тэдний амьжиргаанд хамгийн өндөр эрсдэл дагуулах үзэгдэл бол ган, зуд юм. Ган хэдийгээр малын шууд хорогдогдуулахгүй ч өвлийг давах малын чадавхийг

алдагдуулж, тарга хүч болон өөхөн таргыг бууруулснаар хээл хаях, биеийн жин бага тул эдийн засгийн алдагдалд хүргэн, малыг тамирдуулдаг тул өвчин гарах эрсдэлд хүргэдэг. Харин зудын нөхцөл байдал нь малчин өрхөд шууд, тэр дороо мэдрэгдэх гамшигт нөлөө үзүүлэх эрсдэл учруулдаг.

Зуд бол нийгэм, экологийн ээдрээтэй үзэгдэл юм. Барууны судлаачдын тодорхойсноор, зуд бол олон жилийн дунджаас доогуур агаарын хэмд их хэмжээний хур тунадастай байх цаг уурын үзэгдлийг хэлдэг. Мөн чанартаа бол маш хүйтэн нөхцөлд бэлчээрийн нутагт цас, мөсөн бүрхүүл үүссэнээр мал тэжээгдэх боломжгүй болж, улмаар их хэмжээний малын хорогдол гарах эрсдэл юм. Зунгантай байснаас энэ нөхцөл үүдэх юмуу улам гүнзгийрэх нөлөө үүсдэг гэж үздэг. Харин сүүлийн үеийн судалгаагаар зуд, ган хоёрын хооронд шууд хамаарал байхгүй болох нь тогтоогдоод байна (Стенберг нар 2009). Гэхдээ, миний үзэж байгаагаар эдгээр судалгаа, томъёолол нь тухайн үзэгдлийг буруу тодорхойлж байгаа бөгөөд учир нь Монголчуудын ойлголтоор бол “зуд” хэмээх нэр томъёо нь байгаль орчны нөхцлүүдийн тодорхой нэг хослол бус харин их хэмжээний малын хорогдолттой холбоотой юм. Монголчууд зуд тохиох олон янзын нөхцөл байдлыг ялган үзэж байгаа нь үүнийг батлах бөгөөд тухайлбал, төмөр зуд (мөсөн бүрхүүл үүсэх), хар зуд (гантай зуны араас цасгүй өвөл болох), цагаан зуд (цасан шуургатай байх), хүйтэн зуд (маш бага агаарын хэм), туурайн зуд (бэлчээрийн өвс малын хөлд талхилагдах) зэрэг ангиллыг малчид хэрэглэдэг. Зудыг байгаль цаг агаарын тодорхой нөхцөл байдалтай хамааруулах боломжгүй учраас барууны судлаачид энэхүү үзэгдлийг мөн чанарыг ойлгож, оновчтой тодорхойлолтыг гаргахад бэрхшээлтэй байдал үүсдэг. Ямартаа ч зуд хэмээх энэхүү үзэгдэл экологийн эх сурвалжтай гэдгийг үгүйсгэх аргагүй.

Байгалийн гамшигт нөхцөл байдал үүсэхэд малчин өрхүүд хэд хэдэн стратеги ашиглаж байна. Зудтай нутагт

малчин өрхүүд малын нэмэлт тэжээл ашиглах, малдаа хэвэг, бараашиг тавьж өгөх, малаа нэмнэх зэрэг арга хэрэглэж байна. Зарим малчид малаа өвлийн хүйтнээс хамгаалахын тулд бууцыг хотонд нэмж, саравч барих, салхинаас хамгаалах халхавч босгодог. Гэхдээ л эдгээр нөхцөлд эрсдлээс сэргийлэх үндсэн стратеги нь мал сүрэг болон малчин өрхийн шилжих хөдөлгөөн юм.

Монголын малчин өрхүүдийн шилжих хөдөлгөөний норматив шинжилгээнүүдэд малчин өрхүүд жилдээ дөрвөн удаа улирлын нөхцлийг даган нүүдэллэдэг нь харагддаг. Малчин өрхүүд өөрийнхөө улирлын бууцуудын хооронд шилжин нүүдэг бөгөөд тухайлбал, 8 дугаар сарын сүүл, 9 дүгээр сарын эхээр малчин өрх зуслангаасаа бууж намаржаандаа ирж суурьшина. Хэдийгээр Өгөөмөр багийн ихэнх малчид энэхүү загварыг баримтлахын хичээдэг ч янз бүрийн шалтгаанаар үүнээс олон юмуу цөөн нүүх тохиолдол маш элбэг тохиолддог. Жилийн нүүдлийн тогтсон циклээс гажсан тохиолдолд малчид “отор” хэмээн нэрлэгддэг нүүдэллэх стратегийг хэрэгжүүлнэ. Судлаач миний бие энэхүү судалгааны хүрээнд отрын тухай нэгдсэн тодорхойлолтыг гаргаж чадаагүй болно. Зарим малчин өрх отроор зөвхөн намар явдаг гэж хэлж байсан бол зарим өрхүүд жилийн аль ч цагт оторлож болно гэж хэлж байв. Зарим хүн отрыг малаа тарга авахуулах зорилготой гэж тодорхойлж байхад зарим нь үүнийг ган, зуднаас зугтах арга гэж тодорхойлж байна. Судалгааны зарим материалд оторлох нь тусгайлан хадгалсан “нөөц бэлчээр” лүү нүүх гэж тодорхойлж байхад зарим бүтээлд өөрийн сум, аймаг, тэр ч бүү хэл цөөн онцгой тохиолдолд улс орны хил хязгаарыг давж нүүдэллэх хэмээн тодорхойлж байна. Энэхүү судалгааны хүрээнд оторлох стратегийг судлаач миний бие дөрвөн улирлын явцад ээлжлэн ашигладаг уламжлалт буудаллах нутгаас гарч нүүх гэсэн утгаар тодорхойлж байгаа болно.

Малчин өрхүүдийн ихэнх нь жилийн хугацаанд отроор

тогтмол явдаг бөгөөд голдуу хаврын сүүл, зуны эхээр малын хүчийг сэргээх зорилгоор, мөн намрын цагаар малдаа тарга авахуулахаар оторлодог. Гэхдээ энэ бол оторлох стратегийг хэрэглэх цорын ганц тохиолдол биш юм. Энэхүү судалгааны явцад орон нутгийн нөөцийг илүү оновчтой ашиглах үүднээс малчид өөрсдөө “зохион” хэрэглэж буй оторлох стратегитай би олон удаа таарч байлаа. 20 км-ийн доторх богино отор нь үүнээс хол нүүдэллэх холын отрын стратегиас ихээхэн ялгаатай нь ажиглагдлаа. Богино отор нь голдуу малын хүчийг сэргээх, тарга авахуулах зорилготой бол холын отор нь ган, зуднаас зайлсхийх зорилготой ажээ. Зарим малчин өрх гантай үед юмуу хаваржаа, зуслан, намаржаа, өвөлжөөний нутаг эзэмших боломжгүй үед тодорхой нутаг дэвсгэрт тогтмол нүүдэллэх явдал ч гардаг. Зарим өрхүүд холын оторт урт хугацааны хөрөнгө оруулалт хийж, бүтэн жилээр оторлох нь ч бий. Заримдаа 20 хүртэлх тооны өрхүүд нийлж бүлээрээ нүүдэллэж байхад зарим өрх орон нутгийнхан болон засаг захиргааны анхааралд өртөхөөс болгоомжлон ганцаараа нүүдэллэлэг. Хамаатан садан юмуу цалинтай малчдын хүчийг ашигладаг хүн бүл сайтай өрхүүд мөн л мал сүргээ хэд хэд тасалж, өөр сум, бүр заримдаа өөр аймгийн нутагт суух, айлд малаа тавьж хариулуулдаг. Зарим өрх, ялангуяа ядуу өрхүүд нүүж чаддаггүй тул малын хорогдол амсах эрсдэлд хамгийн ихээр өртдөг.

Малчин өрхийн шилжин нүүдэллэх стратегийн сонголтод хэд хэдэн хүчин зүйл нөлөөлдөг ажээ. Юуны өмнө малын улирлын хэрэгцээ хамгийн чухал нөлөөтэй болох нь тодорхой. Жишээлбэл, намрын улиралд малын тарга хүч, тэжээлд хужир (давс, содын тунадас) хамгийн чухал байдаг. Нутгийн газрын гадаргуун бүрдэл, ургамлын бүтцийн хослол болон байгаль орчны бусад хүчин зүйл малчин өрхийн хэзээ, хаашаа нүүдэллэхэд хүчтэй нөлөө үзүүлдэг. Ажиллах хүчин, мөн ачааны машин хөлслөх, нэмэлт тэжээл худалдаж авах, малын

хороог дулаалах бууц, түлэх хөрзөн, нүүрс худалдаж авах бэлэн мөнгө зэрэг эдийн засгийн нөөц бололцоо нь мөн л малчин өрх хэр хол нүүдэллэж чадах вэ гэдэгт хүчтэй нөлөө үзүүлнэ. Харин шилжин нүүдэллэх шийдвэрт нөлөөлдөг улс төр, соёл, итгэл үнэмшлийн шинжтэй олон хүчин зүйлийг судлаачид өнөөг хүртэл анхаарал хандуулалгүй явж ирсэн нь үнэн. Шинэ нутагт буухын тулд малчин өрх тэнд байгаа нөөцийг ашиглах хүсэлтээ гаргаж, ийм эрхтэй болохоо ямар нэгэн байдлаар батлах үндэслэл гаргах хэрэгтэй болдог. Хэдийгээр сумын захиргаа зуд болвол малчдаа оруулж ирэх отрын гэрээ хийх ёстой ч малчин өрхүүд нутгийн малчидтай эв найрамдалтай хамтран амьдрах тухай харилцан тохиролцох шаардлагатай болдог. Энэ нь нутгийн захиргаа, малчидтай зохицох улс төрийн чадавхитай байхыг малчин өрхөөс шаардагдахын зэрэгцээ иймэрхүү зохицуулалтыг хэрхэн зөвшилцөх, улмаар хэлэлцэж тохирсон зүйлсээ хэрхэн хэрэгжүүлэх талаар маш сайн ойлголттой байхыг шаардана. Энэ нь социализмын үеийн отрын нүүдлийг зохицуулж байсан арга туршлагаас эрс ялгаатай нөхцөл байдал юм. Үүнээс харахад нэгдлийн аж ахуй задарсан нь отрын нутагт орох эрх, отрын нүүдэл хийхэд шаардлагатай нөөцийг олж авахад малчин өрхүүд ямар арга хэрэгслүүдийг ашиглах болсонд маш хүчтэй нөлөө үзүүлсэн нь илт.

Монгол болон Өгөөмөр баг дахь нутгийн удирдлагын институцууд болон хөдөөгийн амьдралын өөрчлөлт

1991 оноос хойш Монголын төр хөдөөгийн орон нутгийн удирдлагын өөрчлөн шинэчлэх өргөн хүрээтэй үйл ажиллагаа хэрэгжүүлсэн бөгөөд харин эдгээр шинэчлэлийн бодлогын хэрэгжилт удааширч, эхлэл төдий байдал илэрч байгаа юм. Сүүлийн 20 жилийн ихэнх хэсэгт орон нутгийн нөөцийн менежментэд төв засгийн газрын оролцоо дутагдсаар ирсэн. Ялангуяа, засаг захиргаа болон төрийн төсөл санхүүгийн төвлөрлийг сааруулах бодлогын нөлөөгөөр үүссэн орон

нутгийн нөөцийг нээлттэй ашиглах зохицуулалтын үр дүнд албан бус институцууд бэхжих орон зай, боломж бүрдсэн байна. 2007, 2008 онд Өгөөмөр багийн нутаг дэвсгэр дээр хийсэн судалгаанаас харахад институцийн эрс өөрчлөлт явагдсан байна. Хөдөө орон нутагт малчдын нутаглах нутгийн хүртээмжийг харилцан туслалцах ёс зүйгээр зохицуулж ирсэн тал нутгийн эдийн засгийн ёс суртахуун өөрчлөгдөн, хөдөө нутаг дах өмчийн эрс шинэ харилцаа үүсэж байгааг энэ судалгааны явцад судлаач миний бие ажигласан юм. Эдгээр шинэ харилцаа нь сүүлийн арваад жилийн засаглалын хүрээний өөрчлөлтүүдээс гадна малын тоо толгойн эрс өсөлт, мал аж ахуй бүтээгдэхүүний үнийн өсөлт, эдгээрээс үүдэлтэй улам бүр өрсөлдөөнт шинжтэй болж буй нөөцийн ашиглалттай холбоотой ажээ.

Энэ нөхцөл байдалд садан төрлийн холбоо хэлхээ бүхий малчдын бүлгүүд нутгийн харилцааны яс, суурь болж, энэхүү суурь дээр тулгуурлан институцийн өөрчлөлт явагдаж байгааг судлаач миний бие ажигласан болно. Товчоор бол, садан төрлийн хэлхээ холбоо доторх нас, хүйсийн шаталсан харилцаа буюу ах, дүүсийн харилцаа нь Өгөөмөр сумын нөөцийн менежментийн суурь зарчим болсон байлаа. Садан төрлийн эдгээр бүлгүүдийн дотор ахмад настан эрэгтэйчүүд буюу ах нар нь эрх мэдлийг гаргаа төвлөрүүлсэн тул нөөцийн менежменттэй холбоотой шийдвэрүүдийг, ялангуяа байгалийн гамшиг нүүрлэсэн үед, өөрсдөө гаргах, заримдаа бусдад шилжүүлэн шийдэх эрх мэдлийг хэрэгжүүлж байлаа. Эдгээр бүлэг нь мөн газар нутгаа хамгаалах янз бүрийн стратеги боловсруулсан байв. Садан төрлийн бүлгүүд тодорхой нутаг дэвсгэрт тархан суурьших замаар тэр нутаг дэвсгэрийг эзлэн, орж ирсэн хүмүүсийг хөөн гаргах тактикийг түлхүү ашиглаж байна. Садан төрлийн өрхүүд хоорондоо стратегийн зайд суурьшин, малаа бэлчээрлүүлэх замаар тухай орон нутгийг эзэлдэг бөгөөд үүгээрээ садан төрлийн бус малчин өрхүүдэд

бэлчээр нутгийг хүртээмжгүй болгодог ажээ. Бусад малчин өрхийг өөрийн газар нутгаас хөөн гаргахын тулд амаар айлган сүрдүүлэх, мөн малыг нь хулгайлах, биед нь халдах аргыг ашигладаг байна.

Тодорхой газар нутгийг эзлэхийн зэрэгцээ малчин өрхүүд мөн эдийн засгийн харилцааны шинэ загваруудыг ашиглах болсон нь энэхүү судалгааны явцад илэрсэн юм. Садан төрлийн бүлгийн мэдэлд уламжлалаараа харъяалагдах болсон өвөлжөө хаваржаа, худаг ус, бүр бэлчээрийн нутагт садан төрлийн бус өөр нэг малчин орох эрхтэй болохын тулд тэдэнд юм зарах, тэднээс юм худалдаж авах, түрээсээр ашиглах, хахууль өгөх, бэлэг өгөх, бусад арга замаар эдийн засгийн солилцоонд орох шаардлагатай болдог тухай малчид ярьж байна. Хэдийгээр бэлэг сэлт өгөх нь уламжлалт ёс зүйд нийцсэн мэт харагдах ч худалдах, түрээслэх болон эдийн засгийн бусад солилцоо нь өмнөх үеэс уламжлагдан ирсэн харилцаанаас эрс ялгаатай юм. Дүгнэн хэлбэл, эдгээр албан бус шинэ зан үйлүүд нь нүүн шилжих шийдвэр гаргаж буй бусад өрхүүдэд шинэ төрлийн зардал болон тусаж байгаа бөгөөд нийгмийн ялгаварлан гадуурхалт, дайсагнасан газар нутгийн өмчлөл бүхий машинд хуваагдмал бэлчээрийн мал аж ахуй орон зайг бий болгож байна.

Энэхүү газрын харилцаанд гарсан албан бус өөрчлөлтүүд нь засаг захиргааны албан зохицуулалтад гарсан өөрчлөлтүүдтэй давхацжээ. Хэдийгээр 1994, 1998, 2002 онуудын эрх зүйн шинэчлэлд туссан ч 2006 оноос л Өгөөмөр багийн харъяалагддаг ИТХ малчдад өвөлжөө, хаваржаа, намаржааны газрын өмчлөх эрхийг олгож эхэлсэн байна. Бодлогын энэхүү томоохон өөрчлөлттэй зэрэгцэн өмчлөлийн газрыг түрээслүүлэх үйл ажиллагааны үндсэн арга хэрэгсэл болсон орон нутагт түшиглэсэн нөөцийн менежментийн шинэ хөтөлбөр IFAD-ийн санаачилгаар хэрэгжиж эхэлжээ. Энэ санаачилгын хүрээнд шинээр байгуулагдсан малчдын


хоршоо хэрэг дээрээ садан төрлийн холбоонд суурилсан орон нутгийн бүлгүүдийн тусгал болж, тэдний газар эзэмших эрхийг түрээсийн гэрээгээр албан ёсны болгож өгсөн бөгөөд улмаар дөнгөж илэрч байсан газар нутгийг эзлэн хүртээмжийг хязгаарлах үзэгдлийг улам газар авхуулсан байна. Үүний дээр, нэгдлийн аж ахуй задран унаснаас хойш бараг ашиглагдахгүй байсаар ирсэн отроор нүүдэллэх гэрээг аймаг, сумын Засаг дарга нар 2007 оны зудны дараагаас сэргээн хэрэглэх болжээ. Энэ гэрээгээр байгалийн гамшигт нөхцөлд малчин өрхүүд өөр орон нутгийн малчид, засаг захиргаанд хөөгдөх айдасгүйгээр холын оторт явах эрхтэй болдог юм. Харин энэхүү гэрээнд багтаах асуудлыг мөн л бэлэг, хээл хахууль оролцуулсан хар улс төрийн аргаар хийж байна.

Эдгээр харилцаа, институцууд нь хөдөөгийн Монголын нийгмийн амьдралд хүчтэй сөрөг нөлөө үзүүлсэн ноцтой үзэгдэл мэт харагдаж болох ч бодит амьдрал дээр эдгээрийн нөлөөлөл нь зөвхөн 2008 оны 1 дүгээр сард тохиолсон зуд шиг гамшигт байдлын үеэр л малчдын амьдралд хүчтэй мэдрэгддэг байна. “Хэвийн” үед эдгээр асуудлын ихэнх нь үл анзаарагдам байдаг бөгөөд учир нь хил хязгаар бол түүнийг давсан тохиолдол л илэрхий болж ирдэг зүйл билээ. Тухайлбал, сайхан жилд нүүж буух хэрэгцээ, шаардлага байхгүй тул өвөлжөө, зуслангийн нутагт орох эрх олж авах асуудал харьцангуй чухал биш болдог. Цаашилбал, өвс ногоо элбэг үед газар нутгаа эзлэн суурьших, гадны хүмүүсийг өөрийн нутгаас хөөх асуудлын ач холбогдол буурдаг. Хэдийгээр газрын түрээсийн гэрээгээр бэхжүүлсэн нийгмийн гадуурхал ямар ч үед анзаарагдам байдаг ч өвлийн отрын гэрээнээс үүдэлтэй нийгмийн гадуурхал гамшиг бэрхшээл нүүрлэсэн нөхцөлд л илэрч гарч ирдэг ажээ. Яг л энэ үед малчин өрхүүдийг эрсдлээс хамгаалах, малын хорогдлоос сэргийлэх хамгаалалтын тогтолцоо малчин өрх бүрт тэгш үйлчилж чадахгүй байгаа нь илэрхий харагдаж байгаа юм.

2008 оны зуд

2007-2008 оны өвлийн улиралд малчин өрхүүдийн малын хорогдлын хэмжээ нь хамгийн эрсдэлт 1 ба 2 дугаар сар дахь эдгээр өрхийн байршлаас хамаарч байна. Хэнтий аймгийн зудад өртөөгүй төв болон хойд сумдын нутагт өвөлжиж байсан өрхүүд малын хорогдол багатай юмуу огт амсалгүй өвлийг давсан. Үнэндээ эдгээр өрх зуднаас зугатаж чадсан юм. Харин эсрэгээрээ нутагтаа үлдсэн, ялангуяа сумын баруун хэсэгт байрлах Өгөөмөр багийн нутгаас нүүж чадаагүй хоцорсон өрхүүд ихээхэн хэмжээний малын хорогдол үзсэн. Жишээлбэл, нэг өрхийн нас гүйцсэн малын 30 шахам хувь нь өлсөж туйлдсанаас хорогдсон байна. Эдгээр эрс ялгаа нь малчин өрхийн нөхцөл байдалд зуд хэрхэн нөлөөлж буйг ойлгоход чухал болоод зогсохгүй мөн өнөөгийн улс төрийн орчинд нөөц болон эрсдлийн менежментийг хэрхэн хийх талаар ойлгоход чухал мэдээлэл болох юм.


Хүснэгт 1. Малын хорогдлын үзүүлэлт малчин өрхийн байршлаар. Баянхутаг сум нь харьцуулах сум болно



Өөр сум руу нүүж явсан малчин өрхүүдийн ихэнх нь өвлийн отроор нүүх гэрээг өөрсдөө юмуу өөрийн орон нутгийн засаг захиргааны тусламжтайгаар бусад сумын захиргаатай хийж чадсан өрхүүд байгаа юм. Үүний дээр тэдний ихэнх нь мөн нүүж очсон нутгийнхаа малчин өрхүүдтэй бэлчээр, өвөлжөө

ашиглах энхийн тохиролцоог хийж чадсан байна. Мөн бүлэг болж нүүсэн малчин өрхүүдийн хүн бүлийн тоо ихтэй байсны ачаар хөөгдөлгүй хүний нутагт өвөлжжээ. Эдгээр бүлгүүд нь голдуу нийгэм, улс төрийн нөлөө ихтэй ахмад насны эрэгтэй хүнээр удирдуулсан бүл чадал сайтай чинээлэг садан төрлийн сүлжээнүүд байсан юм. Мөн эдгээр садан төрлийн сүлжээнүүд нь орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд томоохон төлөөлөлтэй, орон нутгийн улс төрийн намын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог бүлгүүд байв. Тэд өөрсдийн садан төрлийн сүлжээ болон цалинтай малчдаас бүрдсэн ажиллах хүчний нөөц сайтай өрхүүд байв.


Хүснэгт 2. 2007- 2008 оны зудны үеэр малчин өрхүүдийн байршил. Баян-Аварга, Норовлин, Баян-Овоо, Хэрлэн сумдын чинээлэг өрхүүд отрын гэрээнд багтсан байв. Батноров, Мөрөн сумд гэрээ байгуулж чадаагүй болно.



Харин үүнээс ялгаатайгаар отроор явж чадаагүй өрхүүд голдуу ядуу юмуу бүл чадал муутай өрхүүд байв. Ялангуяа, төрөл садан цөөтэй өрхүүд отроор явах эдийн засаг, улс төр, нийгмийн нөөц бололцоог хүртэж чадаагүй тул малаа алдах илүү эрсдэлтэй нүүр тулсан юм. Зөвхөн чинээлэг өрхийн хөлсний малчин болсон юмуу ивээлд нь багтаж чадсан ядуу өрхүүд ихээхэн хэмжээний малын хорогдлоос зайлсхийж

чадсан боловч чинээлэг өрхийн ивээлд багтах, тэдний хөлсний малчин болно гэдэг нь ядуу өрхийн хувьд өөрийн бие даасан байдлаа алдах, цаашилбал, биеэ дааж амьдрах хэмжээнд өөрийн мал сүргийг өсгөх боломжийг алдана гэсэн үг болно. Эдгээр ядуу өрхүүд өөрсдийнх нь хянах боломжгүй олон шалтгааны улмаас мал ахуйгаа алдахад хүрч байна.

Хүснэгт 3. Малын хорогдлын хэмжээ сүргийн хэмжээгээр. Ядуу өрхүүдийн малын хорогдол илүү байгааг анхаарна уу. Малын хорогдол багатай өрхүүд нь хөлсний малчинтай өрхүүд байгаа бол малын хорогдол ихтэй өрхүүд нь голдуу бие даасан өрхүүд байгаа болно.



Дүгнэлт: Эрсдэлд өртсөн төр

2010 оны зуднаар ихээхэн хэмжээний мал хорогдож, малчид гарз хохирол амссан нь олон шалтгаантай, үүний дотор гол нь малчдын буруутай үйл ажиллагаанаас үүссэн байгаль орчны доройтсонтой холбоотой гэж тайлбарладаг. Ямаан толгойг өссөний улмаас бэлчээрийн даац хэтэрсэн явдал нь үүнд нөлөөлсөн нь дамжиггүй ч 2010 онтой харьцуулахад малын тоо толгой хамаагүй бага байсан 1999, 2001, 2002 оны зудны дараа ч ийм л тайлбар өгч байсан. Харин энд миний

судалгааны дүн, зуданд өртсөн өөр газарт хийсэн бусад судалгаанаас харахад малын зүй бус хорогдол нь малчдын буруутай үйл ажиллагаа, залхуурал юмуу хойрго байдлаас бус харин өнөөгийн үндэсний хөгжлийн зорилтуудад мал аж ахуйн эдийн засгийн болон соёлын асуудалд хандуулах анхаарал суларч, улмаар хөдөө орон нутгийн нөөцийн менежмент, гамшгаас сэргийлэх асуудалд орон нутгийн засаг захиргааны оролцоо дутмаг байгаатай холбоотой гэж дүгнэж болох байна. Үүнтэй адил, малын тоо толгойн хорогдлын тархалт тэгш бус байгаа нь төрийн эрх мэдлийг гэрээлэн шилжүүлэх үйл явц нүүдлийн мал аж ахуйн салбарт оролцож буй хүмүүст тэгш бус нөлөөлөл үүсгэж, ядуучуудыг орхигдуулж байгааг харуулж байна. Хөдөөгийн мал аж ахуйн салбар дахь төрийн оролцоог эргэн харж, нийгмийн гадуурхалтад хүргэж буй авилга, хээл хахууль, ивээн тэтгэлт давамгайлсан эдгээр харилцааг нийтэд хүртээмжтэй болгон өөрчилснөөр бид зудны эрсдлээс малчдыг үр өгөөжтэй хамгаалж чадах юм.

Талархал

Энэхүү судалгаанд шаардлагатай санхүүгийн дэмжлэгийг Үндэсний Шинжлэх Ухааны академи (Диссертацийг боловсронгуй болгох тэтгэлэг 0719863), Антропологийн судалгааг дэмжих Веннер Грен сан, Олон улсын Боловсролын судалгааны Фулбрайт хөтөлбөр, Ламбда Альфа Үндэсний Өргөмжлөлт Нийгэмлэг, болон Кентукки мужийн Их сургууль хангаж өгсний зэрэгцээ МУИС, Хөгжлийн судалгааны институт, Америкийн Монгол судлалын төв зэрэг байгууллагууд дэмжлэг үзүүлсэн болно. Мөн судалгааг хийж байх явцад надад зочломтгой хандаж, миний бүхий л асуулт, асуудалд ойлгон хандаж, надад анхаарал халамж тавьж байсан Өгөөмөр, Баянхутаг, Өндөрхаан сумын малчдад хувиасаа гүн талархал илэрхийлье. Мөн Улаанбаатар хотод бага хурал зохион байгуулж намайг урьж оролцуулсан Брюс Кнауфт, Рик

Таупиер, Гэрэлмаа нарт талархал илэрхийлж байна. Энэхүү бага хурал нь Монголын өнгөрсөн түүх болон ирээдүйд чин сэтгэлийн угаас ханддаг хүмүүсийн хувьд нэн сонирхолтой, мэдлэг ойлголтыг тэлсэн үйл явдал болсныг тэмлэглэх хэрэгтэй.

Ашигласан бүтээлийн жагсаалт

Fernandez-Gimenez, Maria and Batbuyan

2004 Law and Disorder: Local Implementation of Mongolia's Land Law. *Development and Change* 35(1): 141-165.

Murphy, Daniel J.

2011 Going on Otor: Mobility, 'Natural' Disaster, and the Political Ecology of Vulnerability in Mongolia. Phd Dissertation, University of Kentucky.

Sneath, David

2001 Notions of Rights over Land and the History of Mongolian Pastoralism.

InnerAsia 3: 41-59.

Sneath, David and Caroline Humphreys

1999 End of Nomadism? State, Society, and Environment in Inner Asia. Duke University Press: Durham.

Sternberg, Troy

2009 Pressurised pastoralism in South Gobi, Mongolia: what is the role of drought? *Transactions of the Institute of British Geographers* 34(3): 364-377.